



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/214

Зуунмол

Төв аймгаас төрөн гарсан
генералуудад хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.1, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 3 хэсгийн 1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад генерал цол бий болсны 78 жилийн ойг тохиолдуулан Төв аймгаас төрөн гарсан генералуудад хүндэтгэл үзүүлж, өсвөр үе хүүхэд залууст цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх, тэдгээрээр бахархах үйл ажиллагааг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хөтөлбөрийн дагуу зохион явуулахыг Цэргийн штаб, (дэд хурандаа Т.Төмөрчөдөр) даалгасугай.


2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар цэргийн дээд цол хүртсэн Монголын анхны эмэгтэй генерал Өндөрширээт сумын харьяат Зэвсэгт хүчний Жанжин штабын Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Ганболдын Болорт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион явуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д хариуцуулсугай.

3. Төв аймгаас төрөн гарсан генералуудын намтар, түүхэн замнал, эдэлж хэрэглэж байсан эд зүйлийг хүлээн авч, аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг угтаж генералуудын үзмэрийг шинэчлэн баяжуулахыг аймгийн Музейн дарга (Б.Сүхбаатар)-д даалгасугай.

4. Аймгаас гарсан генералуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

5. Хүндэтгэлийн арга хэмжээнд шаардагдах 3,785,000 (гурван сая долоон зуун наян таван мянга) төгрөгийн зардлыг аймгийн 2022 оны төсвийн хуваарилагдаагүй зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д, шилэн дансанд байршуулахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР


2022-4-22-ны ажиллагаа
15:00


Аймгийн Засаг даргын 2022 оны 04 -р
сарын 19 -ны өдрийн АЗМ -р
захирамжийн хавсралт



ТӨВ АЙМГААС ГАРСАН ГЕНЕРАЛУУДАД ХҮНДЭТГЭЛ
ҮЗҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнэ	Нийт үнэ
Монголын анхны эмэгтэй генералд Г.Болорт хүндэтгэл үзүүлэх зардал				
1	Мөнгөн аяга	1	500,000	500,000
2	Талархал	1	30,000	30,000
3	Баглаа цэцэг	1	60,000	60,000
4	Нутгийн зураг	1	150,000	150,000
5	Аймгийн бренд	1	40,000	40,000
6	Жаазтай дурсгалын зүйл	1	130,000	130,000
	Бүгд			910,000
Аймгаас төрөн гарсан генералууд				
1	Нүдэн брэнд аяга	11	125,000	1,375,000
2	Жаазтай дурсгалын зүйл	2	130,000	260,000
3	Нутгийн зураг	1	150,000	150,000
4	Талархал	1	30,000	30,000
5	Аймгийн бренд	11	40,000	440,000
6	Хадаг	11	10,000	110,000
7	Гэрэл зураг	12	5000	60000
8	Хоолны зардал	30	15000	450,000
	Бүгд			2875000
	Нийт			3785000

ТӨСӨВ ГАРГАСАН:
ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА
ДЭД ХУРАНДАА  Г.ТӨМӨРЧӨДӨР

ХЯНАСАН:
ТӨРИЙН САНГИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН  Ч.ЦЭЦЭГСҮРЭН

